## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 8 дугаар сарын
28-ны өдөр

Улаанбаатар хот

# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах**

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.

**3 дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох**

3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.

3.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

**4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох**

Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**
**Р.ГОНЧИГДОРЖ**

---